

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2023/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Ари файнэнс аудит” ХХК Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.08.24 № 217

танай _____ -ны № _____ -г

Г ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.БОЛОРМАА ТАНАА

Г Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа

011020203

мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>275,751,652.46</u>	<u>418,825,395.81</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	133,311,388.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	133,311,388.00
3121	Төгрөг	-	133,311,388.00
31211	Төрийн сангийн харилцах	-	133,311,388.00
35	БАРАА МАТЕРИАЛ	275,751,652.46	285,514,007.81
354	Хангамжийн материал	275,751,652.46	285,514,007.81
35410	Бичиг хэргийн материал	1,666,995.20	7,729,383.20
35420	Аж ахуйн материал	187,969,438.34	201,597,201.34
35460	Хүнсний материал	-	45,000.00
35470	Бусад хангамжийн материал	86,115,218.92	76,142,423.27
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,187,761,779.30</u>	<u>4,209,524,060.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,187,761,779.30	4,209,524,060.20
392	Биет хөрөнгө	3,571,822,446.93	3,594,189,727.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,477,077,403.00	3,477,077,403.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,337,510.08)	(191,188,491.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	238,950,146.00	325,124,957.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(212,245,140.13)	(215,794,599.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,875,947.47	132,428,947.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(112,191,512.61)	(115,446,810.06)
39209	Зам, гүүрийн байгууламж	17,766,348.00	17,766,348.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,103,967.80)	(13,324,761.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	253,553,257.00	267,253,257.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(84,522,523.92)	(98,486,307.87)
39217	Ном	-	8,779,785.00
393	Биет бус хөрөнгө	615,939,332.37	615,334,332.49
39301	Програм хангамж	7,282,312.41	7,568,312.41
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,342,980.04)	(7,233,979.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	615,000,000.00	615,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,463,513,431.76</u>	<u>4,628,349,456.01</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,463,513,431.76</u>	<u>4,628,349,456.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,463,513,431.76	4,628,349,456.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,203,895,625.93	1,203,895,625.93
51101	Өмч: - төрийн	1,203,895,625.93	1,203,895,625.93
512	Хуримтлагдсан үр дүн	1,576,070,883.50	1,741,386,907.75
51210	Өмнөх үеийн үр дүн	1,576,070,883.50	(2,886,962,548.26)
51220	Тайлант үеийн үр дүн	-	4,628,349,456.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,683,546,922.33	1,683,066,922.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,463,513,431.76</u>	<u>4,628,349,456.01</u>

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,945,694,854.20	7,421,825,119.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,884,954.20	4,501,733,877.76
120	Нийтлэг татварын бус орлого	18,884,954.20	4,501,733,877.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,884,954.20	1,650,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,650,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	-	4,212,891,564.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	18,884,954.20	287,192,313.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,081,200.00	2,920,091,242.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,780,728,700.00	2,580,321,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,780,728,700.00	2,580,321,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,069,800.00	189,091,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,069,800.00	189,091,542.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,011,400.00	150,678,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,011,400.00	150,678,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,022,943,286.18	2,793,475,663.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,022,943,286.18	2,793,475,663.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,884,929,748.19	2,389,247,988.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,488,544,123.00	1,862,504,418.00
210101	Үндсэн цалин	1,085,785,643.00	1,276,493,074.00
210102	Нэмэгдэл	302,708,776.00	497,555,196.00
210104	Урамшуулал	100,049,704.00	88,456,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,368,337.01	232,446,431.00
210201	Тэтгэврийн даатгал	135,323,869.12	160,554,398.58
210202	Тэтгэмжийн даатгал	14,868,999.46	18,914,207.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,787,678.44	14,980,166.01
210204	Ажилгүйдлийн даатгал	2,762,528.65	3,451,118.78
210205	Эрүүл мэндийн даатгал	27,625,261.34	34,546,540.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,930,032.00	74,403,170.00
210301	Гэрэл, цахилгаан	11,552,372.00	15,780,780.00
210302	Түлш, халаалт	26,511,369.00	30,689,779.00
210303	Цэвэр, бохир ус	16,866,291.00	27,932,611.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,243,297.00	17,098,556.65
210401	Бичиг хэрэг	2,842,640.00	
210402	Тээвэр, шатахуун	1,385,100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,648,600.00	
210404	Ном, хэвлэл	-	16,938,556.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,473,357.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,893,600.00	160,000.00

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	3,954,600.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,045,000.00	
210502	Хоол, хүнс	-	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,909,600.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,804,599.00	11,317,511.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,999.00	
210604	Урсгал засвар	2,779,600.00	11,317,511.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,618,600.00	8,124,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,618,600.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,124,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,466,160.18	183,353,202.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00	49,118,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,711,652.40	40,078,538.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,154,507.78	94,156,064.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,013,537.99	404,227,675.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,012,030.00	404,221,542.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,797,700.00	215,130,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,562,308.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,652,022.00	189,091,542.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,001,507.99	6,133.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,001,507.99	6,133.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(77,248,431.98)	4,628,349,456.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(77,248,431.98)	4,628,349,456.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,926,809,900.00	2,921,741,242.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,650,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,650,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,650,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,650,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,926,809,900.00	2,920,091,242.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,780,728,700.00	2,580,321,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,780,728,700.00	2,580,321,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,069,800.00	189,091,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,069,800.00	189,091,542.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,011,400.00	150,678,200.00

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,011,400.00	150,678,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,926,809,900.00</u>	<u>2,697,641,294.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,926,809,900.00</u>	<u>2,697,641,294.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,788,796,362.01</u>	<u>2,293,368,619.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,488,544,123.00	1,862,504,418.00
210101	Үндсэн цалин	1,085,785,643.00	1,276,493,074.00
210102	Нэмэгдэл	302,708,776.00	497,555,196.00
210104	Урамшуулал	100,049,704.00	88,456,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,368,337.01	232,446,431.00
210201	Тэтгэврийн даатгал	135,323,869.12	160,554,398.58
210202	Тэтгэмжийн даатгал	14,868,999.46	18,914,207.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,787,678.44	14,980,166.01
210204	Ажилгүйдлийн даатгал	2,762,528.65	3,451,118.78
210205	Эрүүл мэндийн даатгал	27,625,261.34	34,546,540.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,930,032.00	74,403,170.00
210301	Гэрэл, цахилгаан	9,807,502.00	15,780,780.00
210302	Түлш, халаалт	28,256,239.00	30,689,779.00
210303	Цэвэр, бохир ус	16,866,291.00	27,932,611.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,375,500.00	10,511,600.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	10,511,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,072,300.00	22,608,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	22,608,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,800,500.00	90,894,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00	56,981,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,200,500.00	33,913,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>138,013,537.99</u>	<u>404,272,675.00</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,012,030.00	404,266,542.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,797,700.00	215,175,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,652,022.00	189,091,542.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,001,507.99	6,133.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,001,507.99	6,133.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	<u>224,099,948.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>90,788,560.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<u>90,788,560.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	90,788,560.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	90,788,560.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(90,788,560.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	133,311,388.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	133,311,388.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,203,895,625.93	1,683,546,922.33	1,576,070,883.50	4,463,513,431.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(4,463,033,431.76)	(4,463,033,431.76)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,203,895,625.93	1,683,546,922.33	(2,886,962,548.26)	480,000.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(480,000.00)	-	(480,000.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	4,628,349,456.01	4,628,349,456.01
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,203,895,625.93	1,683,066,922.33	1,741,386,907.75	4,628,349,456.01

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,732,649,700.00	2,598,932,179.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,732,649,700.00	2,598,932,179.00
210	Бараа, үйлчилгээний зардал	2,512,445,567.00	2,422,974,179.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,969,838,034.00	1,862,504,418.00
210101	Үндсэн цалин	1,457,980,883.00	1,276,493,074.00
210102	Нэмэгдэл	467,632,451.00	497,555,196.00
210104	Урамшуулал	44,224,700.00	88,456,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,498,763.00	232,446,431.00
210201	Тэтгэврийн даатгал	167,793,217.36	160,554,398.58
210202	Тэтгэмжийн даатгал	19,736,218.34	18,914,207.60
210203	ҮОМШӨ ний даатгал	15,758,694.69	14,980,166.01
210204	Ажилгүйдлийн даатгал	3,928,284.77	3,451,118.78
210205	Эрүүл мэндийн даатгал	39,282,347.84	34,546,540.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,403,170.00	74,403,170.00
210301	Гэрэл цахилгаан	15,780,780.00	15,780,780.00
210302	Түлш, халаалт	30,689,779.00	30,689,779.00
210303	Цэвэр, бохир ус	27,932,611.00	27,932,611.00
2105	Нормативт зардал	-	39,217,000.00
210502	Хоол, хүнс	-	39,217,000.00
2106	Эд хогшил худалдан авах	10,517,733.00	10,511,600.00

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	10,517,733.00	10,511,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	22,608,700.00	22,608,700.00
210806	Мэдээллийн технологийн зардал	22,608,700.00	22,608,700.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	89,930,300.00	181,682,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,672,300.00	147,769,860.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,913,000.00	33,913,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	419,289,542.00	175,958,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	419,289,542.00	175,958,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	230,198,000.00	175,958,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,732,649,700.00	2,732,243,567.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,730,999,700.00	2,730,993,567.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,580,321,500.00	2,580,321,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,678,200.00	150,672,067.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,650,000.00	1,250,000.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,650,000.00	1,250,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	133,311,388.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,091,542.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,091,542.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	189,091,542.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	189,091,542.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	189,091,542.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,091,542.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,091,542.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,091,542.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил¹ илэрснээс, 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

2. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцээгүй, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	1	-			1			-
Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.	1	-			1	-		
Нийт дүн	2	-			2	-	2	-